МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

# ИРГЭДИЙН ТӨСӨВ



## МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ 2021

УЛААНБААТАР ХОТ 2020

САНГИЙН ЯАМ

THE WORLD BANK

Монгол Улсын Сангийн яамны санаачилгаар, Европын холбооны буцалтгүй тусламжийн хүрээнд Дэлхийн банкны хэрэгжүүлж буй Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх төслийн санхүүжилтээр уг товхимлыг бэлтгэн гаргав.

Товхимлыг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд “Иргэдийн төсөв-2021, Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл”, Сангийн яам хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу.

Санал хүсэлт байвал Сангийн яамны tusuv@mof.gov.mn цахим шууданд ирүүлнэ үү.

# МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын төсвийн тухай мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй, ойлгомжтой хүргэх зорилгоор 2018 онд Иргэдийн төсөв эмхэтгэлийг Сангийн яамны зүгээс анхлан бэлтгэж эхэлсэн ба өдгөө дөрөв дэх жилдээ Та бүхэнд хүргэж байна.

Засгийн газар өнгөрсөн хугацаанд төсвийн сахилга батыг сайжруулж төсвийн алдагдал, өрийг бууруулахын зэрэгцээ хямралд орсон эдийн засгийг сэргээхэд зайлшгүй шаардлагатай мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж ирлээ. Түүнчлэн бизнес эрхлэгч, татвар төлөгчдөд ээлтэй татвар, гаалийн тогтолцоог бүрдүүлж, цахим, ил тод, үр ашигтай төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлэн, төсвөөс гадуурх зарцуулалтыг хязгаарлаж, өрийн оновчтой бодлого хэрэгжүүлснээр төсвийн орлого нэмэгдэн өрийн дарамт багасаж эдийн засаг тогтвортой өсөх хандлагадаа орсон байна.

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны төсвийн төсөлд цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөллөөр үүссэн төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн тогтвортой байдлыг ханган, мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Мөн татвар нэмэхгүйгээр бизнесийн орчныг үргэлжлүүлэн дэмжиж, гаалийн шинэчлэлийн үр дүнд экспортыг нэмэгдүүлж, баялгаас орох орлогыг бүрэн хураах, технологийн дэвшил ашиглан татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулж, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэн төсвийн орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчилна.

Коронавируст цар тахлын аюул үргэлжилсээр байгааг харгалзан эмзэг бүлгийн иргэдийн орлогыг хамгаалах, аж ахуй эрхлэгчдийг дэмжих чиглэлээр 2020 онд хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг, тухайлбал хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн тэтгэмжийг 2021 оны



эхний хагаст үргэлжлүүлэн олгоно. Түүнчлэн, иргэнийг дагасан, гүйцэтгэл болон эмчилгээний чанарт суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжих эрүүл мэндийн шинэчлэлийн бэлтгэлийг хангаж байна. Багшийг хөгжүүлэх, сургалтын стандарт хөтөлбөр, чанарыг сайжруулахад чиглэсэн үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог боловсролын салбарт нэвтрүүлэх болно.

Дээрх бодлогын арга хэмжээний үр дүнд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 11.8 их наяд төгрөг, нийт зарлага 13.9 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -5.1 хувьтай тэнцэхээр байна.

Эцэст нь дурдахад, Засгийн газрын "Цахим, ил тод, үр ашигтай" бодлогод нийцүүлэн эмхэтгэлийг цахим номын хэлбэрээр хүргэж байгаа нь энэ удаагийн онцлог боллоо.

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

**ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР**

# 4 ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| ААН | Аж ахуйн нэгж |
| АНУ | Америкийн нэгдсэн улс |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| МХХТ | Мэдээлэл, харилцаа, холбоо, технологи |
| НДС | Нийгмийн даатгалын сан |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| НҮБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| НҮТС | Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| УБ | Улаанбаатар |
| УИХ | Улсын их хурал |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ТХЗ | Тогтвортой хөгжлийн зорилт |
| ЭМД | Эрүүл мэндийн даатгал |
| ЭТТ | Эрдэнэс таван толгой |

**ХХХ** тэрбум ▲ **ҮҮ%**

| | |
|---|---|
| ХХХ | 2021 оны оны нэгдсэн төсвийн нийт орлого |
| УУ% | 2020 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад гарсан өөрчлөлтийн хувь |
| Сум | ▲ өсөлт ▼ бууралт |

Нэгдсэн төсвийн нийт орлого
**13,160.0** тэрбум ▲ **22.7%**

Жишээ нь: Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн нийт орлого 13,160.0 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2020 оны батлагдсан төсвөөс 22.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

# АГУУЛГА


## БҮЛЭГ 1. 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН БОДЛОГО, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төсвийн бүрдэлт, хуваарилалт ....7

Монгол Улсын нэгдсэн төсөв ....8

2021 оны төсвийн бодлого ....9

Коронавируст халдварын цар тахлын эсрэг 2020 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ....10

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд ....11

Монгол Улсын нэгдсэн төсвийн онцлог 2018-2021 ....12

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага ....13

Цахим, ил тод төсвийн шинэчлэл ....14

## БҮЛЭГ 2. НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

Төсвийн орлогын чиглэлээр авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ ....16

Төсвийн орлогын бүрдэлт ....17

Татвар нэмэхгүйгээр төсвийн орлогын боломжит эх үүсвэр, нөөц бололцоог дайчилна ....18

Татварын хамрагдалтыг сайжруулна ....20

НӨАТ-ын удирдлагын систем ....21

Экспортыг нэмэгдүүлж, уул уурхайн орлогыг бүрэн хураана ..24

Авто замын сангийн эх үүсвэр – авто зам ашигласны төлбөр ....25

## БҮЛЭГ 3. НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Зарлагын зарчмууд ....26

Улсын төсвийн зарлага, Ерөнхийлөн захирагчаар ....27

Засгийн газрын тусгай сан ....28

Улсын төсвийн хөрөнгө оруулалт ....30

Улс, орон нутгийн төсвийн харилцаа ....33

Салбарын онцлогууд ....35

## БҮЛЭГ 4. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Засгийн газрын өрийн удирдлага ....49

Засгийн газрын өрийн бүтэц ....50

Засгийн газрын гадаад зээл, тусламж ....51

Гадаад зээл, тусламж, хөгжлийн түнш байгууллагаар ....52

# 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН БОДЛОГО, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БҮЛЭГ 1

ТӨСВИЙН БҮРДЭЛТ, ХУВААРИЛАЛТ

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

2021 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГО

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ 2020 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОНЦЛОГ 2018-2021

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

ЦАХИМ, ИЛ ТОД ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

## ТӨСВИЙН ТЭНЦЭЛ:

Төсвийн тэнцэл нь орлого, зарлагын зөрүү.

### АЛДАГДАЛ




Төсвийн алдагдлыг Засгийн газрын үнэт цаас, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлдэг.

### АШИГ




Төсвийн ашгийг дараа оны төсвийн эх үүсвэрт зарцуулдаг.

**ТӨСӨВ:** Монгол Улсын төсөв нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тодорхой хугацаанд буюу тухайн оны 1 сарын 1-ний өдрөөс 12 сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд хуримтлуулах, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөр гэх зэргийг багтаасан хэрэгсэл юм.




### ТӨСВИЙН ЗАРЛАГА

Урсгал зардал

Хөрөнгийн зардал

### ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ






- Цалин
- Тэтгэвэр, тэтгэмж
- Хүүхдийн мөнгө
- Төрийн худалдан авалт
- Халамж гэх мэт

### ТӨСВИЙН ОРЛОГО

Төсвийн нийт орлого нь

1. Татварын орлого
2. Татварын бус орлого

Нийт орлогоос тодорхой хэсгийг Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв санд хуваарилж үлдсэн орлого буюу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор төсвийн зарлагыг санхүүжүүлдэг.





### ТАТВАР

- Орлогын албан татвар
- Хөрөнгийн албан татвар
- Нийгмийн даатгалын шимтгэл
- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Гаалийн татвар
- Онцгой албан татвар

### ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс шалтгаалсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах зорилгоор тус санг 2011 онд байгуулсан.



### ИРЭЭДҮЙН ӨВ САН

Цаашид нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого бөгөөд өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зорилгоор 2017 онд байгуулсан сан юм.

# МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

| УЛСЫН ТӨСӨВ | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ | ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ | ОРОН НУТГИЙН ТӨСӨВ |
|---|---|---|---|
| Монгол Улсын ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, яамд болон түүний харьяа байгууллагуудын захиран зарцуулах төсөв юм. | НДС-ийн орлого нь НДШ болон улсын төсвөөс олгосон санхүүжилтээс бүрдэнэ. Уг орлогыг хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт зарцуулдаг. | ЭМДС-ийн төсөв нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс бүрдэж төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлдэг. | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ТЕЗ бүрдүүлэн, зарцуулах төсөв. Улс орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн хэмжээг УИХ батална. |

### БОЛОВСРУУЛАХ

- **IV.15-VI.1** Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж УИХ-аар батлуулна
- **VI.10-VII.1** Төсвийн хязгаарын саналыг боловсруулж, Засгийн газраар батлуулна
- **VII.25-X.1** Төсвийн төслийн саналыг боловсруулж УИХ-д өргөн барина

ИТХ-д төсвийн төслөө өргөн барина

- **XII.10** Аймаг нийслэлийн Засаг дарга
- **XI.25** Сум, дүүргийн Засаг дарга

### БАТЛАХ

УИХ дараах хуулиудыг хэлэлцэн батална

**XI.15**
- Монгол Улсын төсвийн тухай
- Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай
- Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай.

ИТХ батална

- **XII.5** Аймаг, нийслэлийн төсөв
- **XII.10** Сум, дүүргийн төсөв

### ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн жил
1 сар 1 - 12 сар 31

Хуваарийн дагуу Төрийн санд орлого төвлөрөх ба Төрийн сангаас төсвийн байгууллагууд руу санхүүжилтийг шилжүүлнэ.

Төсвийн гүйцэтгэлийг сар, улирал, хагас жил, жилээр тайлагнана

### ТАЙЛАГНАХ

| Сангийн яам | Төрийн аудитын төв байгууллага | УИХ |
|---|---|---|
| V.10 дотор | 1 сарын хугацаанд | хаврын чуулган |
| Нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан | Аудит хийж Засгийн газар, УИХ-д хүргүүлнэ | Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг батална |

1. Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөллөөр үүссэн төсвийн алдагдлыг 2021 онд бууруулан төсвийн тогтвортой байдлыг хангаж, мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ

2. Цар тахлын үед хэрэгжүүлж буй иргэдийн орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих зарим арга хэмжээг хилийн хориог цуцлах хүртэлх хугацаагаар буюу ирэх оны эхний хагас жилд үргэлжлүүлнэ

3. Татвар нэмэлгүй бизнесийн орчныг үргэлжлүүлэн дэмжиж, гаалийн шинэчлэлийн үр дүнд экспортыг нэмэгдүүлж, баялгаас орох орлогыг бүрэн хураах, технологийн дэвшил ашиглан татварын бүртгэл, хамрагдалтыг сайжруулж, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшнийг нэмэгдүүлж төсвийн орлогын боломжит эх үүсвэрийг дайчилна.

4. Төсвийн урсгал зардлыг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн түвшинд нийцүүлэх, эрүүл мэнд, боловсролын салбарын шинэчлэлийг эхлүүлэх, нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын үйлчилгээг коронавируст халдварт (КОВИД-19) цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалж, нийгмийн эмзэг бүлэгт чиглүүлнэ

5. Ирэх онуудад төлөгдөх гадаад бондуудын эргэн төлөлтийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр өрийн менежмент хийж зохицуулна

6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудыг дуусгана

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ 2020 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Эрүүл мэндийн салбарын эрсдэлийн бэлэн байдлыг хангах

**118.6 тэрбум**

**10 сар - 12 сар**

Мэргэжлийн хяналт, онцгой байдал, цагдаа, хил хамгаалах, гааль зэрэг бусад салбарын бэлэн байдлыг хангах

**6.2 тэрбум**

Эрсдэлийн бэлэн байдлыг хангах зорилгоор Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх

**40.0 тэрбум**

Хүнс, тэжээлийн дэмжлэгийг үргэлжлүүлэх

**6.0 тэрбум**

**4 сар - 12 сар**

Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн

100,000 төгрөг

**66.6 тэрбум**

ААН-ийн жилийн борлуулалтын орлого < 1.5 тэрбум бол ААНОАТ-аас чөлөөлнө

**60.0 тэрбум**

Ковид 19-ийн эм эмнэлэгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлнө

**18.3 тэрбум**

Түрээсийн төлбөрөө бууруулсан ААН-ийг түрээсийн орлогод ногдуулах татвараас чөлөөлөх

**27.5 тэрбум**

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг ~~20,000~~-100,0000 төгрөг

**852.2 тэрбум**

НДШ-ийг хөнгөлнө. Ажил олгогч, ажилтан тус бүр 5%

**144.4 тэрбум**

**4 сар 1 - 10 сар 1**

НДШ болон түүний алданги, торгуулиас чөлөөлнө

**870.0 тэрбум**

**4 сар 1 - 10 сар 1**

1,886.1 тэрбум төгрөг

**10 сар 1 - 12 сар 31**

673.6 тэрбум төгрөг

Нэгдсэн төсвийн алдагдалд үзүүлэх нөлөө 2.5 их наяд төгрөг

ХХОАТ-аас чөлөөлсөн

**175.0 тэрбум**

Ноолуурын урамшуулал олгож, малчдын орлогыг дэмжсэн

**175.0 тэрбум**

## ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

**Дотоодын нийт бүтээгдэхүүн**

Тухайн нутаг дэвсгэрт дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн 1 жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт бараа бүтээгдэхүүн

*/их наяд төгрөг/*




## ГАДААД ХУДАЛДАА

**Экспорт**

Монгол Улсын нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа бараа, үйлчилгээ

**Импорт**

Хилийн чанадаас Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж байгаа бараа, үйлчилгээ

*/тэрбум ам.доллар/*




## ДНБ-ИЙ ӨСӨЛТ

**Эдийн засгийн бодит өсөлт**

Инфляц буюу үнийн өсөлтийн нөлөөллийг тооцсон ДНБ-ий өсөлт

*/хувь/*




## ИНФЛЯЦ

**Инфляцын түвшин**

Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн ерөнхий түвшний өсөлтийн хувь

*/хувь/*




** Хүлээгдэж буй гүйцэтгэл*
*** Төсөөлөл*

# МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОНЦЛОГ 2018-2021

## 2021

- Эрүүл мэнд, боловсролын шинэчлэлийг эхлүүлнэ
- Эмх замбараагүй газар олголтыг бүртгэлжүүлж, хууль бус газар олголтыг таслан зогсоож, ил тод болгоно
- Төрийн өмчийн компаниудын ашигт ажиллагааг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангаж, засаглалыг сайжруулж, орлогыг нэмэгдүүлнэ

## 2020

- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн
- Соёл урлагийн томоохон бүтээн байгуулалтыг эхлүүлсэн

## 2019

- Гааль, татварын шинэчлэлийг хийсэн

  *Гаалийн шинэчлэлээр зарим боомтуудыг олон улсын жишигт нийцүүлэх бүтээн байгуулалтыг эхлүүлж, татварын шинэ багц хуулиар иргэд, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчид татварын таатай орчинд үйл ажиллагаа явуулах боломжтой болсон*

- Агаарын бохирдлыг бууруулсан
- Байгалийн баялгаас анх удаа Ирээдүйн өв санд хуримтлал үүсгэсэн

## 2018

- 500 сая ам.долларын Чингис болон 1 тэрбум юанийн Дим сам зэрэг гадаад бондуудыг төлж барагдуулсан
- Хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөр болон 3 ээлжтэй сургуулиудыг 2 ээлжид шилжүүлэх бодлого хэрэгжүүлсэн
- 2014 оноос хойш нэмэгдээгүй байсан төрийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлсэн

# МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

**ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ**
**-2,153.7 тэрбум**
*ДНБ-д эхлэх хувь -5.1%*

**Татварын орлого**
**10,754.4 тэрбум**

**Татварын бус орлого**
**1,043.4 тэрбум**

**НИЙТ ОРЛОГО 11,797.8 тэрбум**

**Урсгал зардал**
**11,012.0 тэрбум**

**Хөрөнгийн зардал**
**3,498.5 тэрбум**

**Эргэж төлөгдөх цэвэр зээл**
**-558.9 тэрбум**

**НИЙТ ЗАРДАЛ 13,951.6 тэрбум**

**Татварын орлого 10,754.4 тэрбум**

- Орлогын албан татвар 2,885.0 тэрбум
- Нийгмийн даатгалын орлого 1,996.7 тэрбум
- Хөрөнгийн албан татвар 175.7 тэрбум
- Нэмэгдсэн өртгийн албан татвар 2,804.0 тэрбум
- Онцгой албан татвар 939.2 тэрбум
- Тусгай зориулалтын орлого 20.0 тэрбум
- Гадаад үйл ажиллагааны орлого 935.0 тэрбум
- Бусад татвар, төлбөр, хураамж 998.8 тэрбум

**Татварын бус орлого 1,043.4 тэрбум**

- Нийтлэг татварын бус орлого 892.7 тэрбум
- Хөрөнгийн орлого 0.4 тэрбум
- Тусламжийн орлого 150.3 тэрбум

**Урсгал зардал 11,012.0 тэрбум**
- Бараа, ажил үйлчилгээний зардал 4,440.7 тэрбум
- Хүү 1,137.5 тэрбум
- Татаас 325.3 тэрбум
- Урсгал шилжүүлэг 5,108.4 тэрбум

**Хөрөнгийн зардал 3,498.5 тэрбум**
- Барилга байгууламж 2,258.5 тэрбум
- Их засвар 88.0 тэрбум
- Тоног төхөөрөмж 383.9 тэрбум
- Бусад хөрөнгө 752.6 тэрбум
- Стратегийн нөөц хөрөнгө 15.4 тэрбум

**Эргэж төлөгдөх цэвэр зээл -558.9 тэрбум**
- Эргэж төлөгдөх зээл -749.9 тэрбум
- Гадаадын төслийн зээл 191.0 тэрбум

# ЦАХИМ, ИЛ ТОД ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЦАЛИНГИЙН НЭГДСЭН СИСТЕМ

- ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО
  Хүний нөөц, цалин хөлс, урамшууллын бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх боломж бүрдэнэ
- ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ
  Төсвийн төлөвлөлтөд бүх шатны эрх захирагчдын цалингийн бодит мэдээллээр шуурхай хангагдана.
  Төсвийн сахилга батыг сайжруулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах
- ШУУРХАЙ ТӨЛБӨР ТООЦОО
  Цалинг албан хаагчдын нэрийн дансанд цахимаар олгож төлбөр тооцоог хялбаршуулах, суутгал болон татварыг шууд төвлөрүүлэх



## ИРГЭДИЙН ТӨСӨВ ЦАХИМ ХУУДАС

- Төсвийн ил тод байдлыг хангах
- Төсвийн талаарх иргэдийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх
- Төсвийн ойлголтыг энгийн ойлгомжтой байдлаар хүргэх
- Иргэд төлсөн татварынхаа зарцуулалтад хяналт тавих боломжоо олгох





https://publicinvestment.gov.mn

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем

- Иргэд, олон нийтэд зориулсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аппликейшнийг улам боловсронгуй болгож, төрийн үйлчилгээг ил тод хүртээмжтэй болгоно.
- Мэдээллийн нэгдсэн дата төвийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулж, сүлжээний тоног төхөөрөмж, системийн программ хангамжийг суурилуулан мэдээллийн нэгдсэн баазыг бий болгоно.
- Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тайлан бүртгэл, хяналтын системийн нэгдсэн дэд бүтцийг бий болгох ажлыг эхлүүлнэ.



## ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС

- Монгол Улсын төсөв, санхүүгийн мэдээллийг олон улсын туршлага, судалгаанд үндэслэн бүтэцчилж, эмх цэгцтэй, уялдаа холбоотой болгоно.
- Төсвийн мэдээллийн нээлттэй, ил тод, иж бүрэн байдлыг хангана.
- Тоо мэдээлэл гараар оруулах ажлыг хөнгөвчилж, систем хооронд мэдээлэл солилцдог байдлаар хөгжүүлнэ.
- Системийн ашиглалт, мэдээлэл хайх ажлыг хялбарчилж, хэрэглэгч төвтэй болгоно.



## ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

- “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” болон аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх болон цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын иж бүрэн мэдээлэл авах
- Олон нийтийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх

БҮЛЭГ 2.

# НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮРДЭЛТ

ТАТВАР НЭМЭХГҮЙГЭЭР ТӨСВИЙН ОРЛОГЫН БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭР, НӨӨЦ БОЛОЛЦООГ ДАЙЧИЛНА

ТАТВАРЫН ХАМРАГДАЛТЫГ САЙЖРУУЛНА

НӨАТ-ЫН УДИРДЛАГЫН СИСТЕМ

ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЖ, УУЛ УУРХАЙН ОРЛОГЫГ БҮРЭН ХУРААНА

АВТО ЗАМЫН САНГИЙН ЭХ ҮҮСВЭР – АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

# ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

1. Татвар нэмэхгүйгээр бизнесийг дэмжиж төсвийн орлогын боломжит эх үүсвэр, нөөц бололцоог дайчилна.
2. Гаалийн шинэчлэлийн үр дүнд ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдуулах татварыг бүрэн хураах, экспортыг хялбаршуулна.
3. Технологийн дэвшил ашиглан татварыг хялбаршуулан, бүртгэлийг сайжруулж, татварын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

## 2021 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО



Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн орлогоор тооцдог. Төсвийн нийт орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв санд хуваарилаад үлдэх хэсгийг Төсвийн тэнцвэржүүлсэн орлого гэнэ.




## ОРЛОГЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР




## УУЛ УУРХАЙН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР



# ТАТВАР НЭМЭХГҮЙГЭЭР ТӨСВИЙН ОРЛОГЫН БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭР, НӨӨЦ БОЛОЛЦООГ ДАЙЧИЛНА

**ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛНА**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ, АШИГТ АЖИЛЛАГААГ НЭМЭГДҮҮЛЭХ

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫГ АЖЛЫН ҮР ДҮНТЭЙ УЯЛДУУЛАН ТОМИЛОХ, ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

ЗАСАГЛАЛ САЙЖРУУЛЖ, ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ

**ИНГЭСНЭЭР НЭМЭГДЭХ ОРЛОГО**

Ногдол ашгийн орлого



Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар



**ГАЗРЫН БҮРТГЭЛ, ТӨЛБӨРИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ**

1. Газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг цахимжуулж, ebarimt аппликейшнд өөрийн бүртгэлээр нэвтрэн орж “Төрийн үйлчилгээ” цэсийн тусламжтайгаар цаг алдахгүйгээр газрын төлбөр, ногдуулалтыг гар утсаараа хүлээн авч, төлөх боломжтой болно.

2. Нийслэл, орон нутгийн хэмжээнд олгосон газрын эрхийг бүртгэх, баталгаажуулах ажлыг энэ ондоо бүрэн дуусгана.



3. Газрын кадастрын мэдээллийн санд газрын мэдээллийг бүрэн оруулах ажилд иргэдийг уриалж, газрын бүртгэлийн мэдээллийг оруулах аян зарлана.

4. Өмчлөлд, ашиглалд болон эзэмшилд байгаа газрыг бүрэн бүртгэж нэгж талбарын мэдээллийг олон нийтэд цахимаар ил тод мэдээлнэ.

Эдгээр ажлыг энэ ондоо багтаан хийж гүйцэтгэснээр улсын хэмжээнд олгогдсон бүх газарт татвар, төлбөрийн ногдуулалт хийгдэж, иргэд цахимаар нэхэмжлэл хүлээн авч газрын төлбөрөө богино хугацаанд хялбар төлөх боломжтой болно.




**1. Барааны импортын мэдээ**

**2. Барааны борлуулалтын мэдээ**

**3. Барааны худалдан авалтын мэдээ**

## НЭГДСЭН СИСТЕМИЙН ҮР ДҮН

- Импортын барааны борлуулалтын бүх шат дамжлагыг бүртгэлжүүлнэ;
- Тамхи, согтууруулах ундаа болон онцгой албан татвартай барааны гарал үүсэл, импортолсон, үйлдвэрлэсэн хугацаа, хуурамч эсэхийг иргэд ebarimt систем ашиглан гар утсаараа хянах боломжтой;
- Татваргүй барааны дэлгүүрээр татвараас зайлсхийх явдлыг таслан зогсооно;
- Эмийн бүтээгдэхүүний чанарт хяналт тавих боломжтой;
- Импорт, экспортын мах, махан бүтээгдэхүүнд хяналт
- Автомашины худалдаа эрхлэгч хувь хүмүүс /ченж/-ийн орлогыг



Бид дэлгүүрээс тамхи, согтууруулах ундаа худалдаж авахдаа ebarimt аппликейшн ашиглаад хуурамч эсэхийг шалгаж болно гэсэн үг үү?

Тиймээ. Тамхи, согтууруулах ундаанаас гадна худалдаж авч байгаа автомашинаа хүртэл гар утсан дээрх ebarimt аппликейшнийг ашиглан тухайн бүтээгдэхүүний гарал үүсэл, Монгол Улсад орж ирсэн огноо, үйлдвэрлэсэн хугацаа, хуурамч эсэхийг хянах боломжтой.



# ТАТВАРЫН ХАМРАГДАЛТЫГ САЙЖРУУЛНА

Газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь **хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэхийг ebarimt-аар** хүргүүлэн, богино хугацаанд цахимаар хялбар байдлаар төлөх боломж олгоно.




Техник технологийн дэвшлийг ашиглан бүх татвараа гар утаснаасаа төлөх боломжтой болсноор заавал төрийн байгууллага болон банкинд очиж цаг алдах шаардлагагүй төлсөн татвараа хянах болно.

Нүүрс экспортлоход шаардлагатай зөвшөөрлүүдийн хүсэлтийг **нэгдсэн системд цахимаар гаргаж, хүний хүчин зүйл орохгүй,** цахимаар түргэн шуурхай олгож экспортыг хялбаршуулна.




**Ашигт малтмалын экспортын тээвэр эрхлэх этгээдэд олгодог "С зөвшөөрөл", гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн зөвшөөрлийн хүсэлтийг нэгдсэн системд цахимаар гаргаж, хүнд суртлыг бууруулж, хүний хүчин зүйл орохгүйгээр, цахимаар түргэн шуурхай олгож, экспортыг хялбаршуулах арга хэмжээ авна.**

## EBARIMT СИСТЕМД ХУДАЛДАН АВАЛТЫН БАРИМТ БҮРТГҮҮЛЭХ ПРОЦЕСС




## EBARIMT 2.0 СИСТЕМИЙН БОЛОМЖ - 2020

**Баримт бүртгүүлэх** */камер нээх/*

- QR код уншуулах
- Баримтын код болон үнийн дүнг оруулж бүртгүүлэх
- Мобайл мессежээр бүртгүүлэх
- Хялбар бүртгэлээр бүртгүүлэх /тусгай дугаарт мессеж илгээх, бүртгэлийн кодоо уншуулах/
- QRbarimt үүсгэх

**Төрийн үйлчилгээ**

- Лавлагаа авах, төлбөр төлөх
- Үйлчилгээний төлбөр төлөх
- Хүсэлт гаргах

Үүсгэсэн нэхэмжлэлийн дагуу төлбөр төлөх

Төлбөр төлсөн төрийн үйлчилгээний мэдээллээ харах

Монгол Улсын иргэн бүрийн цахим шууданг идэвхжүүлэх, бүртгэх



- Хувийн мэдээллээ засварлаж хадгалах
- Татвар төлөгчтэй холбоотой баримтын талаарх гомдол гаргах
- Баримтын төлөв, баримтын ангилалын хянах самбар
- Цахимаар татвар төлөгчөөр бүртгүүлэх, нэхэмжлэх үүсгэх, татвар төлөх
- EBARIMT-нд шинэ функц нэмэгдэх бүрд мэдэгдэл ирнэ
- Facebook chatbot системийн түгээмэл асуултууд

Төлсөн татварын дүнгээ харах

QRbarimt баталгаажуулах

Хувь хүний олсон орлогыг бүртгэх, хялбаршуулсан тайлан гаргах

## EBARIMT ХЭРЭГЛЭГЧ

**Насны ангилал**




**2020 онд баримт бүртгүүлсэн хэлбэр**




- Хэрэглэгчийн тоо 1,651,452
- Монгол улсын 15-с дээш насны иргэдийн 73% нь ebarimt ашигладаг
- Өдөрт дунджаар 1.5 сая баримт бүртгэгддэг
- Өдөрт дунджаар 1 сая баримт баталгаождаг
- Өдөрт дунджаар 510,000 хүн ebarimt системд ханддаг
- 145-н төрийн үйлчилгээний төлбөрийг ebarimt ашиглан төлөх боломжтой
- Улирал бүр дунджаар 920,000 иргэн НӨАТ-ын буцаан олголт авч байна
- Өдөрт дунджаар 1,095 иргэн “Үндэсний цахим шуудан” ebarimt ашиглаж нээсэн байна
- 1.6 сая иргэн 5-н төрлийн татвараа 5 секундийн дотор төлөх боломжтой
- 21 хоногт 1072 хувьцааны ногдол ашиг авах 579,218 иргэний хүсэлтийн дагуу гүйлгээг амжилттай шилжүүлсэн

# НӨАТУС-БИЗНЕС ЭРХЛЭГЧ ХУВЬ ХҮН, ААН

## EBARIMT ПРОЦЕСС




## INVOICE.EBARIMT.MN СИСТЕМИЙН БОЛОМЖ - 2020




### ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

Үндсэн цэсээс гэрээ цэсэнд хандаж түрээсийн гэрээ бүртгэх боломжтой.

### УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

Баримт шивэх талбарт “УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО”-ыг сонгож төлбөрийн баримт үүсгэх боломжтой.

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Баримт шивэх талбарт “ХУВЬ ХҮНД ОЛГОСОН ОРЛОГО”-ыг сонгож иргэний регистрийн дугаараар төлбөрийн баримт үүсгэх боломжтой.

### БАРИМТ БУЦААЛТ ЭЦСИЙН ХЭРЭГЛЭГЧ

Эцсийн хэрэглээнд баталгаажсан баримтыг тухайн сардаа ААН болон иргэний аль нэг нь буцаах хүсэлт гаргаж нөгөө тал нь баримт буцаах хүсэлтийг баталгаажуулснаар төлбөрийн баримтыг буцаах боломжтой.

### QRBARIMT БАТАЛГААЖУУЛАЛТ

“Төлбөрийн баримт” цэсний “EBARIMT-Р ХИЙГДСЭН БАРИМТЫН ЖАГСААЛТ”-ын “Баталгаажаагүй баримт” хэсэгт хандаж үүссэн QRbarimt-ийг ‘БАТАЛГААЖУУЛАХ’ буюу ‘ЦУЦЛАХ’ боломжтой.

## EBARIMT ИНФОГРАФИК

EBARIMT систем 2016 онд нэвтэрснээр татварын орлого 2017 онд 78%, 2018 онд 26%, 2019 онд 63%-иар тус тус өмнөх оноос өссөн.

2019 оны байдлаар НӨАТ-ын орлого нь нийт татварын орлогын 20% орчмыг бүрдүүлж байна.

2015-аас 2019 он буюу 5 жилийн хугацаанд НӨАТ-ын орлого 124%-ийн өсөлттэй байна.

## I. АШИГТ МАЛТМАЛЫН ОЛБОРЛОЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТЫН ҮЕ ШАТ БҮРД EBARIMT СИСТЕМД БОРЛУУЛАЛТЫН ГЭРЭЭ, ЛАБОРАТОРИЙН ДҮГНЭЛТИЙН ХАМТ БҮРТГЭГДЭНЭ.



1.1. Олборлогч: ЭТТ ХХК

1.2. Лабораторид шинжлүүлж, GS код авна.

1.3. GS кодоор бараа, бүртгэлийн нэгдсэн системд бүртгэнэ.

1.4. Ачилт хийгдсэнээр төлбөрийн баримт үүснэ.

Гэрээ
Нэмэлт гэрээ эсэх
Гэрээний дугаар
Зөвшөөрсөн огноо
Гэрээний валютын дүн
Өмнөх гэрээний дугаар
Компанийн РД
Тоо хэмжээ, үнийн дүн
Бүтээгдэхүүний төрөл

ҮР ДҮН: БҮРТГЭЛИЙГ САЙЖРУУЛСНААР ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХ БОЛОМЖГҮЙ БОЛНО.

## II.УХААЛАГ ГАРЦУУД, ГААЛИЙН ЛАБОРАТОРИ, ДЭЭЖ АВАГЧ, ӨНДӨР ХҮЧИН ЧАДЛЫН РЕНТГЕН БАЙГУУЛЖ, ХИЛ НЭВТРЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ АВТОМАТ БОЛГОНО.

2.1. Радио давтамжит илрүүлэлтээр машины бүртгэлийг хийнэ.

2.2 Автомат рентгенээр машин доторх ачааг шалгаж, пүүгээр жинг тодорхойлно.

2.3. Автомат дээж авагчаар дээж авч, үзүүлэлтийг шинжилж, лабораторийн шинжилгээтэй тулгалт хийнэ.

2.4. Монгол-БНХАУ-ын хилээр гарна.




**ТАЙЛБАР**

Ашигт малтмалыг олборлохоос эхлээд хил гаргах хүртэл үйл ажиллагаа бүхэлд нь бүртгэлжүүлж, автомат болгосноор ашигт малтмалд ногдох татварыг бүрэн хураах боломжтой болохоос гадна эрдэс баялгийн экспортод тавих хяналт сайжирна.

**ҮР ДҮН**

ЭКСПОРТЫН АШИГТ МАЛТМАЛЫН ЖИН, АГУУЛГА, ЧАНАРЫГ БҮРЭН ТОДОРХОЙЛЖ ТАТВАРЫГ БҮРЭН ХУРААНА

# АВТО ЗАМЫН САНГИЙН ЭХ ҮҮСВЭР – АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

## ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### ОНОШИЛГООГООР



2019 оны байдлаар Улаанбаатарт бүртгэлтэй нийт 568.9 мянган тээврийн хэрэгслийн 35 хувь буюу 200.4 мянган тээврийн хэрэгсэл оношилгоонд ороогүй, татвар төлөөгүй байна.

### ЗАМЫН ПОСТООР




Цаасан тасалбартай, хүний оролцоо өндөртэй, хураалтын хяналт сул.

Постоор дамжин өнгөрөхөд зарцуулах хугацаа их, замын түгжрэл үүсгэх сөрөг нөлөөтэй.

## ШИЙДЭЛ






*Дугаар таних камер суурилуулж машин бүрийн төлбөрийг бүртгэж хураана. Авто замын постуудыг цаашид*

*Жолооч нарт ebarimt, цахимаар, мессежээр сануулга хүргүүлж, цахимаар төлбөрөө хялбараар төлөх боломж олгоно.*



# НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

БҮЛЭГ 3

ЗАРЛАГЫН ЗАРЧМУУД

УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА, ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХАРИЛЦАА

САЛБАРЫН ОНЦЛОГУУД

## ЗАРЛАГЫН ЗАРЧМУУД

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын төсөл боловсруулахад баримталсан зарчим:

**ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНД НИЙЦСЭН БАЙХ**

Урсгал зардлын нийт хэмжээ нь Монгол Улсын 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан нэгдсэн төсвийн дээд хязгаараас хэтрэхгүй байна.

**ҮР АШИГТАЙ БАЙХ**

Санхүүжилтийн механизмыг нь өөрчлөх замаар **эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын** салбарт тогтолцооны шинэчлэл хийж төсвийг нь дахин хуваарилж, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.

**ХЭМНЭЛТТЭЙ БАЙХ**

Ухаалаг, хэмнэлттэй техник, технологийн дэвшлийг ашиглан бүх шатны төсвийн байгууллагын захиргааны удирдлага, үйлчилгээ болон хөрөнгийн ашиглалтын зардлыг бууруулна.

**ИЛ ТОД, ШУУРХАЙ БАЙХ**

Бүх салбарын тусгай зөвшөөрөл олгох процессыг цахимжуулж, мэдээллийг ил тод, ойлгомжтой болгож, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх боломжийг бүрдүүлнэ.

БОДЛОГО:

1. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 2020 оны түвшинд хадгална.
2. Төсөвт байгууллагуудын урсгал зардлыг дахин хуваарилж, нэмж зардал төсөвлөхгүйгээр шинэ хөрөнгө оруулалттай холбоотой орон тоо, байр ашиглалтын зардал болон бусад урсгал зардлыг шийдвэрлэнэ.
3. Төрийн албан хаагчийн орон тоог нэмэгдүүлэхгүй. Салбаруудын орон тоог цахим системээр баталгаажуулж давхардсан болон илүүдэл орон тоог дахин хуваарилах болон бууруулах замаар цалин хөлсний зардлын өсөлтийг хязгаарлана.
4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эрсдэлтэй нүүр тулж ажиллаж байгаа төрийн байгууллагаас бусад төсөвт байгууллагын тэвчиж болох урсгал зардлыг бууруулна.
5. Өргөдөл гомдол шийдвэрлэх, тусгай зөвшөөрөл олгох процесс болон иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулж, эдгээртэй холбоотой орон тоо, урсгал зардал, цаг хугацааг хэмнэнэ.

## УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА, ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР

*/тэрбум төгрөг/*

| Ерөнхийлөн захирагч | Урсгал зардал | Хөрөнгийн зардал | Гадаад зээл тусламж | Эргэж төлөгдөх цэвэр зээл | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Сангийн сайд | 1,706.7 | 301.1 | 1,415.4 | -502.1 | 2,769.1 |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 2,227.8 | 31.1 | | | 2,258.8 |
| Боловсрол, шинжлэх ухааны сайд | 1,374.7 | 362.3 | | 3.8 | 1,740.7 |
| Эрүүл мэндийн сайд | 663.5 | 75.9 | | | 739.4 |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд | 600.2 | 28.4 | | -20.6 | 608.0 |
| Монгол Улсын Шадар сайд | 172.4 | 262.7 | | | 435.1 |
| Зам, тээврийн хөгжлийн сайд | 12.0 | 288.7 | | | 300.6 |
| Батлан хамгаалахын сайд | 277.5 | 9.2 | | | 286.6 |
| Барилга, хот байгуулалтын сайд | 20.0 | 179.2 | | 5.0 | 204.2 |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 155.4 | 27.4 | | 4.1 | 186.9 |
| Монгол Улсын Ерөнхий сайд | 126.7 | 50.1 | | | 176.8 |
| Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | 145.7 | 18.6 | | | 164.3 |
| Соёлын сайд | 46.8 | 100.0 | | | 146.8 |
| Гадаад харилцааны сайд | 97.2 | 4.3 | | | 101.6 |
| Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга | 63.8 | 29.6 | | | 93.5 |
| Эрчим хүчний сайд | 29.7 | 56.1 | | | 85.8 |
| Улсын ерөнхий прокурор | 52.7 | 25.5 | | | 78.2 |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | 57.3 | 4.0 | | | 61.3 |
| Улсын Их Хурлын дарга | 43.6 | | | | 43.6 |
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | 11.0 | 29.2 | | | 40.1 |
| Авлигатай тэмцэх газрын дарга | 28.7 | 1.1 | | | 29.8 |
| Сонгуулийн ерөнхий хорооны дарга | 28.1 | | | | 28.1 |
| Монгол Улсын Ерөнхий аудитор | 20.7 | | | | 20.7 |
| Үндэсний статистикийн хорооны дарга | 11.1 | | | | 11.1 |
| Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга | 8.9 | 1.1 | | | 10.0 |
| Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга | 5.4 | | | | 5.4 |
| Санхүүгийн зохицуулах хорооны дарга | 5.4 | | | | 5.4 |
| Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч | 5.2 | | | | 5.2 |
| Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга | 4.3 | | | | 4.3 |
| Төрийн албаны зөвлөлийн дарга | 3.0 | | | | 3.0 |
| Үндсэн хуулийн цэцийн дарга | 2.4 | | | | 2.4 |
| Хүний эрхийн үндэсний комиссын дарга | 1.5 | | | | 1.5 |
| **Нийт** | **8,009.6** | **1,733.4** | **1,415.4** | **-509.8** | **10,648.6** |

# ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН

/тэрбум төгрөг/

## ЕРӨНХИЙ САЙД

1 Спортыг дэмжих сан **0.7 тэрбум**

Нийтийн биеийн тамир, Үндэсний спортын төрлийг хөгжүүлэх, өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг бэлтгэх, судалгаа, шинжилгээ хийх, сэргээшийн эсрэг хяналт, сургалт, сурталчилгааг зохион байгуулах



## БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

1 Боловсролын зээлийн сан **49.7 тэрбум**

Санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох замаар гадаад, дотоодын их, дээд сургуульд боловсрол эзэмшихэд туслах



2 Шинжлэх ухаан, технологийн сан **5.8 тэрбум**

Шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх

## БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

1 Байгаль орчин, уур амьсгалын сан **1.2 тэрбум**

Байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

## СОЁЛЫН ЯАМ

1 Соёл хөгжүүлэх сан **2.0 тэрбум**

Соёл, урлагийг хөгжүүлэх, таниулах, соёлын өвийг бүртгэх, хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилготой. Уг сангийн үйл ажиллагааны зардал шинээр байгуулагдсан "Жижиг, дунд үйлдвэрийн газар" руу шилжсэн.



2 Хөдөө аж ахуйг дэмжих сан **33.9 тэрбум**

Газар тариалан, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих

## САНГИЙН ЯАМ

1 Засгийн газрын нөөц сан **40.0 тэрбум**

Төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг санхүүжүүлэх



2 Төсвийн тогтворжуулалтын сан **156.0 тэрбум**

Шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх

3 Ирээдүйн өв сан **1,180.1 тэрбум**

Нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх



## БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

1 Зэвсэгт хүчний хөгжлийн сан **35.0 тэрбум**

Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**1** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан **99.6 тэрбум**



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1-д заасан үйл ажиллагааг санхүүжүүлэх

**2** Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан **81.4 тэрбум**

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг санхүүжүүлэх

**3** Нийгмийн даатгалын сан **2,594.3 тэрбум**

НДС-аас тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн даатгалын байгууллага, үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардлыг санхүүжүүлэх

**4** Нийгмийн халамжийн сан **1,390.3 тэрбум**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан эх үүсвэрээр сангийн орлого бүрдэж нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээнд зориулагдана

## ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

**1** Хилийн чанадад байгаа Монгол иргэдэд туслах сан **0.2 тэрбум**

Хилийн чанадад байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний бүртгэл, консулын үйлчилгээг сайжруулах



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

**1** Эрүүл мэндийг дэмжих сан **3.0 тэрбум**

Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх

**2** Эрүүл мэндийн даатгалын сан **1,238.8 тэрбум**

Даатгуулагчийг өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо хийх, эмчлэх, сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх болон спортоор хичээллэх үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

**1** Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан **0.6 тэрбум**

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**1** Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан **3.9 тэрбум**

Алслагдсан орон нутагт харилцаа холбооны үйлчилгээг хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх



## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

**1** Улсын авто замын сан **55.0 тэрбум**

Төсвөөс урсгал зардал 3.0 тэрбум, хөрөнгийн зардал 52.0 тэрбум. Олон улс, улсын болон нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар, түүнтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг байршлаар харуулбал:




## УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж

| Ангилал | Төслийн тоо | 2021 онд санхүүжих /тэрбум төгрөг/ | Нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь |
|---|---|---|---|
| Нийслэл | 293 | 430.7 | 31.0% |
| Орон нутаг | 701 | 691.4 | 49.8% |
| Улсын хэмжээнд | 35 | 262.5 | 18.9% |
| Элчин сайдын яамд | 2 | 4.3 | 0.3% |
| **Нийт** | **1031** | **1,388.9** | **100%** |

*“Барих-Шилжүүлэх” төрлийн концессоор 1,063.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 9 төсөл, арга хэмжээ байгаа ба 2021 онд 316.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэхээр төлөвлөөд байна.*






## КОНЦЕСС

“Чойр” дэд станцын өргөтгөл, шинэчлэлт (Говьсүмбэр, Сүмбэр сум)

Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5км хатуу хучилттай авто зам төсөл

Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167км хатуу хучилттай авто зам төсөл (Завхан)

### ШИЛЖИХ

300 ортой төрөх эмнэлгийн барилгыг дуусган дэд бүтэц барих төсөл (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)

### ШИНЭ

Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7км хатуу хучилттай авто зам төсөл (Баянхонгор)

Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6км хатуу хучилттай авто зам төсөл

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

### ЦЭЦЭРЛЭГ
- Шинэ: 29 төсөл
- Шилжих: 75 төсөл
- 173.9 тэрбум — Нийт төсөвт өртөг
- 77.3 тэрбум — 2021 онд санхүүжих

### ЭМНЭЛЭГ
- Шинэ: 21 төсөл
- Шилжих: 36 төсөл
- 189.1 тэрбум — Нийт төсөвт өртөг
- 57.3 тэрбум — 2021 онд санхүүжих

### СУРГУУЛЬ
- Шинэ: 14 төсөл
- Шилжих: 85 төсөл
- 393.1 тэрбум — Нийт төсөвт өртөг
- 168.6 тэрбум — 2021 онд санхүүжих

### ДОТУУР БАЙР
- Шинэ: 5 төсөл
- Шилжих: 19 төсөл
- 33.5 тэрбум — Нийт төсөвт өртөг
- 15.2 тэрбум — 2021 онд санхүүжих

### АВТО ЗАМ
- Шинэ: 12 төсөл
- Шилжих: 51 төсөл
- 506.6 тэрбум — Нийт төсөвт өртөг
- 137 тэрбум — 2021 онд санхүүжих

### СОЁЛЫН ТӨВ
- Шинэ: 7 төсөл
- Шилжих: 30 төсөл
- 67.8 тэрбум — Нийт төсөвт өртөг
- 24.5 тэрбум — 2021 онд санхүүжих

### СПОРТ ЦОГЦОЛБОР
- Шинэ: 1 төсөл
- Шилжих: 10 төсөл
- 98.7 тэрбум — Нийт төсөвт өртөг
- 13.8 тэрбум — 2021 онд санхүүжих

### ГҮҮР
- Шинэ: 6 төсөл
- Шилжих: 11 төсөл
- 50.9 тэрбум — Нийт төсөвт өртөг
- 26.5 тэрбум — 2021 онд санхүүжих

Шинэ
Шилжих

## ОНЦЛОХ ТӨСЛҮҮД

### ЧИНГИС ХААНЫ МУЗЕЙ
2020 онд төсөвт батлагдаж 2021 онд дуусна

67.9 тэрбум төгрөг | 4.3 тэрбум төгрөг

### ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТР
2020 онд төсөвт батлагдаж 2022 онд дуусна

152.5 тэрбум төгрөг | 5.0 тэрбум төгрөг

### ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦЫН КЛАСТЕР
2020 онд төсөвт батлагдаж 2022 онд дуусна

94.0 тэрбум төгрөг | 9.0 тэрбум төгрөг

### БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ
2020 онд төсөвт батлагдаж 2022 онд дуусна

94.5 тэрбум төгрөг | 20.0 тэрбум төгрөг

Улсын болон орон нутгийн төсөв хооронд тусгай зориулалтын шилжүүлэг, орлогын шилжүүлгүүд хийгдэхээс гадна аймгууд болон нийслэл ашгаасаа хамааран улсын төсөвт орлого төвлөрүүлж эсвэл санхүүгийн дэмжлэг авдаг.



# УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОЖ БУЙ САНХҮҮЖИЛТ



**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Зорилт 2.1** Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.

## БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ.

**Сургуулийн өмнөх боловсрол**

**Ерөнхий боловсрол**

**Их дээд сургууль**

### 1 Цэцэрлэгийн хүүхдийн хоол

Ердийн цэцэрлэгт:

2,475 ₮ + 1,000 ₮ = 3,475 ₮

24 цагийн, сувиллын болон тусгай цэцэрлэг

3,600 ₮ + 1,000 ₮ = 4,600 ₮

1 хүүхдийн өдрийн тариф

Нэмэгдэл | Шинэ тариф

Зардлыг эцэг эхээс төлүүлэх хамтын санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ.

### 2 Цахим үнэлгээний систем

Суралцагчийг сурлагын амжилтаар нь үнэлэх цахим систем бий болгож боловсролын чанарыг үнэлнэ.

### 3 Багшийн үнэлгээний систем

Багшийг суралцагчийн сурлагын ахиц дэвшлээр үнэлнэ. Бусад ач холбогдол багатай үнэлгээг бууруулна.

### 4 Цахим сургалтын систем

Заах арга зүй, багшийн мэргэжил дээшлүүлэх э-контентийг бүтээнэ.

### 5 Санхүүжилтийн аргачлал

Суралцагчийн сурлагын амжилттай уялдуулсан багшийн цалин хөлсний шударга тогтолцоог бий болгож, цахимаар олгоно.

### 6 Сургуулийн зураглал /School mapping/

GIS (Geographic Information System буюу Газарзүйн мэдээллийн систем)- д суурилсан сумдын сургуулийн дахин загварчлалыг хийнэ.

### 7 Дээд боловсролын шинэчлэл

Их, дээд сургуулиудыг чанараар нь эрэмбэлж, зөвхөн шилдэг -10 сургуульд суралцдаг оюутанд Боловсролын зээлийн сангаас зээл олгоно.

### 8 Тэргүүлэх, нэн шаардлагатай мэргэжлийг дэмжинэ

Ирээдүйгээ харсан, өнөөдөр ажиллах хүчний дутагдалтай байгаа хэрэгцээт буюу тэргүүлэх, нэн шаардлагатай мэргэжлээр суралцагсдыг Боловсролын зээлийн сангаас дэмжинэ.

## Боловсролын салбарын бодлогын арга хэмжээнүүд

- Сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой үнэ төлбөргүй цахимаар ашиглах, түрээслэх, худалдан авах зэрэг олон хувилбарыг нэвтрүүлнэ.
- 2021 онд **71** сургууль, **49** цэцэрлэг, **16** дотуур байр, **11** сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.
- Сургууль, цэцэрлэгт нэн шаардлагатай тоног төхөөрөмж, их засварын санхүүжилтийг шийдвэрлэнэ.
- Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.

## 2021 оны Боловсролын зээлийн сангийн төсөв — 49.7 тэрбум

| | |
|---|---|
| Оюутны хөгжлийн зээл | 24.8 тэрбум |
| Гадаадад суралцагсдын зээл | 9.0 тэрбум |
| Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, 3 хүүхэд нь зэрэг суралцдаг суралцагчдад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг | 6.0 тэрбум |
| Сувилагч мэргэжлээр төрийн өмчийн их дээд сургуульд суралцагсдын тэтгэлэг | 5.9 тэрбум |
| Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох тэтгэлэг | 2.8 тэрбум |
| Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг | 0.7 тэрбум |
| Үйл ажиллагааны зардал | 0.42 тэрбум |



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 4. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

Тогтвортой хөгжилд хүргэх боловсролын 10 зорилгыг Монгол Улс амжилттай хэрэгжүүлж байна.

| | | Эрэгтэй | Эмэгтэй |
|---|---|---|---|
| Мэдээлэл, харилцаа, холбоо, технологи ашиглах чадвар[1] | 15-49 нас | 20% | 17% |
| Бичиг үсгийн хэрэглээний чадвар[2] | 30-34 нас | 88.8% | 94.4% |
| | 35-39 нас | 86.5% | 92.1% |
| Хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй иргэд[3] | 15-24 нас | 18.4% | 21% |

| Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдийн хувь | | 2018-2019 он | 2019-2020 он |
|---|---|---|---|
| | Бага анги 6-10 нас | 3.4% 15.300 хүүхэд | 3.2% 15.100 хүүхэд |
| | Дунд анги 11-14 нас | 2.0% 13.800 хүүхэд | 2.5% 13.800 хүүхэд |

[1] Судалгаанаас өмнөх 3 сард компьютер ашиглахтай холбоотой тусгайлсан үйлдлүүдийг хийсэн 15-49 насны хүн амын хувь, мөн тусгайлсан 9 үйлдлийн наад зах нь нэгийг хийсэн 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, ҮСХ (2018) Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС).
[2] НҮТС (2018, хуудас 54)
[3] ҮСХ 1212.mn

## НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХЭД 7.2 тэрбум



Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалт

2,039,507 ₮ | 6,248



Мэдээлэл, харилцаа, холбооны ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа

3,075,636 ₮ | 5,427



Бичиг үсэг, тоо тооллын хэрэглээний чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа

2,050,424 ₮ | 2,605

## ХҮРЭХ ҮР ДҮН

**4.4.1** МХХТ ашиглах чадвартай 15-49 насны хүн амын эзлэх хувь

| Он | Эрэгтэй | Эмэгтэй |
| --- | --- | --- |
| 2030 | 60% | 60% |
| 2025 | 50% | 50% |
| 2021 | 21% | 21% |
| 2020 | 17% | 20% |

**4.3.**Хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны залуусын хувь

| Он | Эрэгтэй | Эмэгтэй |
| --- | --- | --- |
| 2030 | 8.4% | 11% |
| 2025 | 13.4% | 16% |
| 2021 | 17.4% | 20% |
| 2020 | 18.4% | 21% |

**4.6.1** Бичиг үсэг, тоо тооллын хэрэглээний чадвар нь тогтсон түвшинд хүрсэн хүн амын эзлэх хувь

| Он | Эрэгтэй | Эмэгтэй |
| --- | --- | --- |
| 2030 | 95% | 99% |
| 2025 | 90% | 97% |
| 2021 | 88% | 95% |
| 2020 | 87.6% | 94.4% |

**4.1** Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдийн хувь*

| Он | Бага боловсрол | Дунд боловсрол |
| --- | --- | --- |
| 2030 | 0.6% | 0.5% |
| 2025 | 1.6% | 1.3% |
| 2021 | 2.6% | 2.0% |
| 2020 | 3.2% | 2.5% |

- (улаан) БШУЯ НҮТС (2018)-аар гаргасан
- (ягаан, ногоон) БШУЯ-ны тооцсон ТХЗ-4-ийн хүрэх түвшний үзүүлэлтүүд.
- (шар) БШУЯ-ны "Нотолгоо ба үр дүнд суурилсан төсөвлөлийн аргачлал"-аар боловсруулсан НТБ хөтөлбөрийн төсвийн санал.

*https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0400_063V1

# НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

## 1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИНЭЧЛЭЛ

Хувийн хэвшилд ажиллаж байгаа даатгуулагчийн зарим шимтгэлийг эхний **6** сар тэглэнэ.

*Хувь хүнд хэрхэн нөлөөлөхийг “ААА” компанийн ажилтан Болдын сарын цалингийн тооцооны жишээ дээр харвал:*



Ажил олгогч
Ажилтан

*Болдын цалин*:*
**1,500,000₮**

| 2021 оны 1-6 сарууд | НДШ** | 2021 оны 7-12 сарууд |
|---|---|---|
| -127,500 ₮ | Тэтгэвэр (Ажил олгогч 8.5%, Ажилтан 8.5%) | -127,500 ₮ |
| 0 ₮ | Тэтгэмж (Ажил олгогч 1%, Ажилтан 0.8%) | -12,000 ₮ |
| 0 ₮ | Ажилгүйдэл (Ажил олгогч 0.2%, Ажилтан 0.2%) | -3,000 ₮ |
| 0 ₮ | ҮОМШӨ*** (Ажил олгогч .8-2.8%) | - |
| -30,000 ₮ | Эрүүл мэндийн даатгалын шимтгэл (Ажил олгогч 2%, Ажилтан 2%) | -30,000 ₮ |
| 1,342,500 ₮ | ХХОАТ хасахаас өмнө | 1,327,500 ₮ |
| -134,250 ₮ | ХХОАТ (Ажилтан 10%) | -132,750 ₮ |
| **1,208,250 ₮** | Гарт олгох | **1,194,750 ₮** |

* Үндсэн цалин болон нэмэгдлийн дүн
** Ажилтны төлөх шимтгэлийн хувиар тооцоог хийсэн
*** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

3 сангийн хувийг тэглэснээр нийт НДШ-ийн хувь 3-5 нэгжээр буурч байна.

## 2 ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙГ БҮХ ХҮҮХДЭД ОЛГОНО



НИЙТ ТӨСӨВ **864** тэрбум

2021 оны 1-6 сарууудад **100,000.0 ₮**

2021 оны 7-12 сарууудад **20,000.0 ₮**

## 3 ХАЛАМЖИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛНЭ.

2021 онд шинээр **15** халамжийн үйлчилгээг цахимжуулна.

***Ингэснээр:** 36 нэр төрлийн бүрдүүлэх материалыг цахимаар авдаг болж иргэдэд учрах чирэгдэл багасна.*

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг иргэдийн дансанд шууд шилжүүлнэ.

***Ингэснээр:** Банканд очих шаардлагагүй болж цаг хугацаа хэмнэнэ.*

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН БАГЦЫН УРСГАЛ ЗАРДАЛД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ:



**6,4 тэрбум ▼**

Зарим халамжийн бус шинж чанартай арга хэмжээг (алдар цолтой ахмад настны мөнгө) харьяалах ТЕЗ-ийн төсвөөс олгоно.




**100.5 тэрбум ▲**

Хувийн хэвшилд ажиллаж буй даатгуулагчийн НДШ-ийн хувийг бууруулсантай холбоотойгоор өсч буй нийгмийн даатгалын сангийн алдагдалд олгох татаас.

Иргэд шимтгэл төлж нийгмийн даатгалд хамрагдсанаар өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болоход өөрт нь эсвэл даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх үүсдэг.

## НИЙТ САНГИЙН ОРЛОГО 2,398.8 тэрбум ▲ 34.4%

| Тэтгэврийн даатгал | Тэтгэмжийн даатгал | ҮОМШӨ-ний даатгал | Ажилгүйдлийн даатгал | Улсын төсвөөс олгох татаас | ЭМДС-ийн шилжүүлэг |
|---|---|---|---|---|---|
| 1,635.6 тэрбум | 124.0 тэрбум | 111.7 тэрбум | 26.6 тэрбум | 499.9 тэрбум | 1.1 тэрбум |
| 68.2% | 5.2% | 4.7% | 1.1% | 20.8% | 0% |

Нийт орлогод эзлэх хувь

## НИЙТ САНГИЙН ЗАРДАЛ
2,490.5 тэрбум ▲ 4%

Бие даасан үндсэн дөрвөн сан тус бүрдээ өөр, өөрийн онцлог зориулалт бүхий тэтгэвэр, тэтгэмжийг олгодог



**Тэтгэврийн даатгалын сан — 2,313.4 тэрбум**

Өндөр настны тэтгэвэр **1,761.7 тэрбум**
Тахир дутуугийн тэтгэвэр **294.9 тэрбум**
Цэргийн тэтгэвэр **173.3 тэрбум**
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр **82.4 тэрбум**
Бусад **1.1 тэрбум**

**Тэтгэмжийн даатгал сан — 160.2 тэрбум**

Жирэмсэн болон амаржсан эхийн тэтгэмж **110.0 тэрбум**
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж **26.4 тэрбум**
Оршуулгын тэтгэмж **16.4 тэрбум**
Бусад **7.4 тэрбум**

**ҮОМШӨ-ний даатгал сан — 34.6 тэрбум**

ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж **30.6 тэрбум**
ҮОМШӨ-тэй даатгуулагчийн сувиллын зардал **2.0 тэрбум**
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал **1.9 тэрбум**

**Ажилгүйдлийн даатгал сан — 58.9 тэрбум**

Ажилгүйдлийн тэтгэмж **58.9 тэрбум**

**Бусад зардал**

Нийгмийн даатгалын үйл ажиллагаа явуулахад шаардагдах бусад зардлууд **27.1 тэрбум**
Авлага **-103.7 тэрбум**

# ХАЛАМЖИЙН САН

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА 2021 ОНД**

**1,390.3 тэрбум** **ТӨГРӨГ БАЙХААР ТӨЛӨВЛӨЛӨӨ.**



ХҮҮХДЭД ОЛГОХ МӨНГӨН ТЭТГЭМЖ

**864.0** тэрбум ▼20.9%



ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР

**165.7** тэрбум ▲5.3%



ЦАЛИНТАЙ ЭЭЖ

**110.7** тэрбум ▲0%



АСАРГААНЫ ТЭТГЭМЖ

**57.1** тэрбум ▲3.4%



ХҮНСНИЙ ТАЛОН

**33.7** тэрбум ▼41.6%

БУСАД

**2.1** тэрбум ▲10.5%



АЛДАРТ ЭХИЙН ТЭТГЭМЖ

**29.9** тэрбум ▲1.7%



АХМАД НАСТНУУДАД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ

**26.1** тэрбум ▲0%

НАСНЫ ХИШИГ

**22.9** тэрбум ▲0%



ЖИРЭМСЭН ЭХИЙН ТЭТГЭМЖ

**16.3** тэрбум ▲6.9%



АМЬЖИРГААГ ДЭМЖИХ ТУСЛАМЖ

**42.9** тэрбум ▲18.8%



АЙМГИЙН ХАЛАМЖИЙН САН

**6.4** тэрбум ▲1.6%



АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

**0.3** тэрбум ▲50%



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ТЭТГЭМЖ

**12.3** тэрбум ▲0%

**Цэргийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.**



Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг олгоно.

43.2 тэрбум ▲ 15.9%

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал олгоно

12.3 тэрбум ▲ 15.2%

- Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулж, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулдаг болно.
- Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу зорчих эрхийг хязгаарлах ялыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэнэ.

Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг зөрчлийн гаралтыг бууруулна.

**Хууль зүйн салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна.**

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн хүний нөөцийн чадавхыг сайжруулж, эрүүл мэндийн чанарыг дээшлүүлнэ.

Шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлнэ.



Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл, гудамж талбайд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах зорилгоор 140 хүүхдийн байцаагчийн орон тоог нэмэгдүүлэхээр төсөвлөсөн. Ингэснээр хүүхдийн хамгаалалтай холбоотой гэмт хэргийн гаралт 20-30 хувиар буурах боломжтой.

“Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.

- Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулна.
- Оюуны өмчийн шинэчлэсэн хуулийг хэрэгжүүлснээр хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, цахим гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах, цахимжуулах, боловсронгүй болгоно.

Иргэнээ дагасан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг олгож **эрүүл мэндийн салбарын реформыг** санхүүгийн хөшүүргэт тулгуурлан хэрэгжүүлнэ.



- Бүх шатны эмнэлэг, эмийн сан, эрүүл мэндийн даатгал, иргэнийг холбосон цахим систем бий болно
- Хөнгөлөлттэй эмийг бүх шатны эмнэлгийн эмч бичиж, бүх эмийн сан олгодог болно
- Стандартын шаардлага хангаагүй, хуурамч эмийг зах зээлээс шахаж, эмийн чанар сайжирч, үнэ бодитой болно
- Эмнэлэг гүйцэтгэлээрээ санхүүжилт авч, эмч, ажилчдын цалинг үр дүнтэй уялдуулж нэмэгдүүлэх боломж бүрдэнэ
- Иргэд эрүүл мэндийн даатгалаараа улсын болон хувийн эмнэлгээс сонгож үйлчлүүлдэг болно

Эрүүл мэндийн салбарын санхүүжилт 1,405.6 тэрбум төгрөг болж 2020 оны төсвөөс 225.3 тэрбум төгрөг буюу 19.1 хувиар өснө.



Гүйцэтгэлд суурилсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо руу шилжинэ



Байгууллагаас төлөх шимтгэл
**181.4**
тэрбум төгрөг

Иргэдээс төлөх шимтгэл
**177.6**
тэрбум төгрөг

Улсын төсвөөс шилжүүлэх
**580.8**
тэрбум төгрөг

Бусад орлого
**11.6**
тэрбум төгрөг

**САНГИЙН НИЙТ ОРЛОГО**
**951.5**
**ТЭРБУМ ТӨГРӨГ**

**САНГИЙН НИЙТ ЗАРЛАГА**
**1,238.8**
**ТЭРБУМ ТӨГРӨГ**

**1,002.5** тэрбум төгрөг — Эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж, үйлчилгээний зардал

**Үүнээс:**
Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад олгох ТЗШ — **198.7** тэрбум төгрөг

**60.0** тэрбум төгрөг — Эмийн сангуудад олгох эмийн үнийн хөнгөлөлт

**14.8** тэрбум төгрөг — Үйл ажиллагааны зардал

**161.6** тэрбум төгрөг — Бусад зардлууд

## БИЕИЙН ТАМИР, СПОРТ

Улсын биеийн тамир, спортын хороо байгуулна. Улсын биеийн тамир, спортын хороог байгуулж 21 аймагт үйл ажиллагаа явуулж байгаа биеийн тамир, спортын асуудал хариуцсан нэгжийг тус спортын хороонд харьяалуулахаар төлөвлөсөн.

> 2020 оноос шилжиж байгаа 7 спорт цогцолбор, 6 спорт заал, 1 соёл, спортын цогцолбор, 1 спортын ордон, 1 цэнгэлдэх хүрээлэнгийн барилга байгууламжийг 2021 онд ашиглалтад оруулна

**Улсын биеийн тамир, спортын хороо /тохируулагч агентлаг/**






21 аймагт үйл ажиллагаа явуулж байгаа биеийн тамир, спортын асуудал хариуцсан нэгжийг улсын төсөв болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

### Улсын төсвөөс

Улсын биеийн тамир, спортын хорооны зардал болон Орон нутгийн нэгжийн байр ашиглалттай холбоотой зардлаас бусад зардлыг санхүүжүүлэх бөгөөд нийт **7.9 тэрбум төгрөг** төсөвлөсөн.

### Орон нутгийн төсвөөс

Байр ашиглалтын зардал буюу дараах зардлыг хариуцдаг байхаар тусгасан

- Гэрэл цахилгаан
- Халаалт
- Цэвэр бохир ус
- Түрээс
- Урсгал засвар



### Орон нутгаас санхүүжүүлснээр дараах ач холбогдолтой

- Өмчийн эзэн нь өмчийнхөө ашиглалтыг бүрэн хариуцдаг
- Өмчийн ашиглалт, хамгаалалт сайжрах
- Өр авлага үүсгэхгүй байх
- Үр ашиггүй хөрөнгө оруулалт, урсгал болон их засварын зардал буурна.

АГААРЫН БОХИРДЛЫН ЭСРЭГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ТЭМЦЭНЭ.



| | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|
| Эрүүл мэндийн сайд | 1,985.0 сая | 2,385.0 сая | **2,385.0 сая** |
| Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | 21,002.1 сая | 59,013.6 сая | **59,306.4 сая** |
| Орон нутгийн засаг захиргаа | 75,221.1 сая | 77,050.0 сая | **81,673.7 сая** |
| НИЙТ | 98,208.2 сая | 138,448.6 сая | **143,365.1 сая** |




2020 онд Нийслэлийн агаарын бохирдлыг 40.3% бууруулсан.
2021 онд нийслэлийн утааг 80% бууруулж, аймгийн төвүүдийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг үргэлжлүүлнэ.

## 1 ГАЗАР НУТГИЙГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримтад тусгагдсан зорилтуудыг үе шаттай хэрэгжүүлэх үүднээс баримталж буй бодлогууд:



Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн унаган төрх, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах



Байгаль, түүх, соёлын үнэт өв, ховордсон амьтан, ургамал болон газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол, мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалахад онцгой ач холбогдол бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, хойч үедээ өвлүүлэн үлдээж, тогтвортой хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлэх

**Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь**




Эх сурвалж: БОАЖЯ
* 2020 оны тодотгол

## 2020 ОНД

**Улсын тусгай хамгаалалтад**



**32.8 сая га газар**

(Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 21%)

## 2021 ОНД

**Улсын тусгай хамгаалалтад**



Монгол орны нийт нутаг дэвсгэрийн **22 хувийг** Улсын тусгай хамгаалалтад авна.

**Улсын тусгай хамгаалалтад авсан:**

- **Шинээр авсан 1.4 сая га газарт** хамгаалалтын менежмент нэвтрүүлнэ
- **Улсын төсвийн хөрөнгөөр 27.9 сая га газарт** хамгаалалтын менежментийн чанарыг сайжруулна.

## 2 ГАЗРЫН ДОРОЙТОЛ, ЦӨЛЖИЛТИЙГ СААРУУЛАХ

Эх сурвалж : *Монгол орны цөлжилтийн судалгаа (2016 он)

**23.2%**

**22.9%**
Нэн хүчтэй болон хүчтэй зэрэглэлээр доройтсон

**53.9%**
Дунд болон сул зэрэглэлээр доройтсон

**76.8%**
Цөлжилт, газрын доройтолд өртсөн нийт нутаг дэвсгэр

- **49%** хүний хүчин зүйл
- **51%** байгалийн хүчин зүйл

“Алсын хараа-2050” бодлогын бичиг баримтад зааснаар хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулах чиглэлээр 2021 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

- Элсний механик хаалтыг 50 га-д хийх
- Цөлжилтөд ихээр нэрвэгдсэн бэлчээрийн газруудыг сонгон авч хашиж хамгаалах




ИРГЭДИЙН ТӨСӨВ 2021
ӨРГӨН БАРЬСАН ТӨСВИЙН ТӨСӨЛ

# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

БҮЛЭГ 4

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БҮТЭЦ

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ, ХӨГЖЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГААР

# ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

### ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИ

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд хамгийн бага зардлаар санхүүжүүлэхэд чиглэнэ.

**ЗОРИЛТ 1.**
Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдлийг бууруулна

**ЗОРИЛТ 2.**
Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж, тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна

**ЗОРИЛТ 3.**
Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ



**ЗОРИЛТ 4.**
Орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг бүрдүүлнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, зах зээлийн нээлттэй өрсөлдөөнт, хүртээмжтэй байдлыг хангаж, Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулна

**ЗОРИЛТ 5.**
Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлнэ.

Улсын нийт гадаад өр гэж Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжээс Монгол Улсад бүртгэлгүй, байнга оршин суугч буc аливаа этгээдэд төлөх өр төлбөрийг хэлнэ.

**УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР**
- Хувийн ахуйн нэгжүүдийн гадаад өр
- Арилжааны банкуудын гадаад өр
- Монгол банкны гадаад өр
- Засгийн газрын гадаад өр

**ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР**
- Засгийн газрын гадаад өр
- Өрийн баталгаа
- Засгийн газрын дотоод өр
- Барих-шилжүүлэх төрлийн концесс

Харин Засгийн газрын өр нь төсвөөс зээлдүүлэгчид төлөх гадаад болон дотоод өр төлбөрөөс гадна барих-шилжүүлэх төрлийн концесс, аж ахуйн нэгж байгууллагуудад гаргасан өрийн баталгаанаас бүрддэг.

Засгийн газраас Коронавируст халдварын цар тахлын эдийн засаг, нийгэмд үзүүлсэн хор хохирлыг бууруулах арга хэмжээний хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит бус чуулганаар "Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай" хуулийг баталсан.
Тус хуулиар Төсвийн зарим тусгай шаардлагыг буюу Засгийн газрын/(ӨҮЦ) өрийн үлдэгдлийн ДНБ-нд эзлэх хувь хэмжээг мөрдөх хугацааг 1 жилээр хойшлуулсан.



### Засгийн газрын нийт өрийн бүтэц




### Хүүгийн зардал




Засгийн газар стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны гадаад төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 2020 оны 9 сарын 28-ны өдөр 600.0сая ам.долларын 5.125%-ийн купонтой "Номад" бондыг арилжаалж 2021 онд төлөгдөх 10.875%-ийн купонтой 500.0 сая ам.долларын "Мазаалай" бонд, 2022 онд төлөгдөх 5.125%-ийн купонтой 1.0 тэрбум ам.долларын "Чингис" бондоос тус тус буцаан худалдан авсан.

Тус арга хэмжээг авч хэрэгжүүлснээр гадаад үнэт цаасны дундаж купоны хувь 7.0%-иас 6.3% болж буурч, нэг жилд төлөгдөж байгаа гадаад үнэт цаасны хүүгийн зардал 26.7 сая ам.доллароор хэмнэгдэж байна.

### Олон улсын зах зээлд арилжаалсан Засгийн газрын гадаад үнэт цаас

| № | Гадаад үнэт цаас | Арилжаалсан огноо | Дүн Сая $ | Купон | Төлөгдөх огноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Чингис | 2012.12.05 | 500$ | 4.125% | 2018.01.05 |
| 2 | Чингис | 2012.12.05 | 1,000$ | 5.125% | 2022.12.05 |
| 3 | Дим сам | 2015.06.30 | 161$ | 7.500% | 2018.06.30 |
| 4 | Мазаалай | 2016.04.06 | 500$ | 10.875% | 2021.04.06 |
| 5 | Хуралдай | 2017.03.09 | 600$ | 8.750% | 2024.03.09 |
| 6 | Гэрэгэ | 2017.10.26 | 800$ | 5.625% | 2023.05.01 |
| 7 | Номад | 2020.09.28 | 600$ | 5.125% | 2026.04.07 |

# ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Монгол Улсын хөгжлийг дэмжих зорилгоор гадаад улс болон олон улсын байгууллагууд Засгийн газарт буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл олгодог.




- Гадаад зээл **1,265.1 тэрбум**
- Тусламж **150.3 тэрбум**



Азийн хөгжлийн банк, БНХАУ, Энэтхэг болон Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслүүд Засгийн газрын 2021 оны гадаад зээл, тусламжийн дийлэнх буюу 78 хувийг эзэлж байна.

